



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/292

Алтай хот

**Газар эзэмших эрхийг дуусгавар
болгож эрхийн гэрчилгээг хүчингүйд
тооцох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн эзэмшилд шилжүүлэх хүсэлт гаргасан иргэн Ц.Мөнхцэцэгийн 8208002140 нэгж талбарын дугаартай 302 м2 орон сууцны зориулалттай газар, "Өргөө засал" ХХК-ийн 8208005055 нэгж талбарын дугаартай 300 м2 орон сууцны зориулалттай газар, "Алтай орон сууцны корпораци" ААТҮГ-ийн 8208005526 нэгж талбарын дугаартай 679 м2 орон сууцны зориулалттай газар, иргэн М.Батаагийн 8208002263 нэгж талбарын дугаартай 288 м2 орон сууцны зориулалттай газрын газар эзэмших эрхийг цуцалж, хавсралтаар баталж нийтийн эзэмшилд тус тус шилжүүлсүгэй.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны 130, 2019 оны А/448, 2020 оны А/501, 2007 оны 168 дугаар захирамжийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Газрын төлбөрийн ногдлоос хавсралтад дурдсан холбогдох хэсгийг хасаж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 4
дугаар сарын 01-ны өдрийн 232 дугаар
захирамжийн хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШИЛД ШИЛЖИЖ БАЙГАА
ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ, БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

Д/д	Иргэний нэр	Иргэний регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Газрын хэмжээ (м.кв)	Нэгж талбары н хаяг	Газар эзэмшилтийн зориулалт
1	Ц.Мөнхцэцэг	ДЭ66112806	8208002140 /060726050/	302.0	Жинст баг	Орон сууц (2203)
2	"Өргөө засал" ХХК	3244911	8208005055	300.0	Жинст баг	Орон сууц (2203)
3	"Алтай орон сууцны корпораци" ААТҮГ	3253821	8208005526	679	Баянхайр хан баг	Орон сууц (2203)
4	М.Батаа	ХВ66010118	8208002263 /060727073/	288	Жинст баг, Хөгжил хороолол	Орон сууц (2203)

__оОо__